

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 03-р сарын 26 өдөр

Дугаар 01

Хархорин сум

Компанийн 2015 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлантай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.9 дүгээр заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 03-р сарын 26 өдөр

Дугаар 02

Хархорин сум

2015 оны ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05/2016 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46.6 дахь заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу нийт 443,357.56 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан 2015 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 03-р сарын 26 өдөр

Дугаар 03

Хархорин сум

Компанийн дүрмийн шинэчилсэн
найруулгыг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1-ийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
2. Тогтоол гарсантай холбоотойгоор “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн 2012 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлагдсан дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбоотойгоор дүрмийг Улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид Улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн хуулбарыг тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Р.Саранцэцэг/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТГЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 03-р сарын 26 өдөр

Дугаар 04

Хархорин сум

Компанийн 2016 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 03-р сарын 26 өдөр

Дугаар 05

Хархорин сум

“Хархорин үндэсний цэцэрлэг” төслийн
хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хэрэгжүүлж буй “Хархорин үндэсний цэцэрлэг” чацарганы төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах үйл ажиллагаа явуулах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай. Үүнд:

1.1. Компанийн эзэмшлийн талбайд тус бүр 200 га хэмжээтэй нийт 15 бичил чацарганы цэцэрлэгийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоотойгоор байгуулах;

1.2. Тогтоолын 1.1-т заасан бичил цэцэрлэг байгуулахтай холбоотойгоор “Хархорин” ХК-ийн 50-с доошгүй хувийн оролцоотой хамтарсан компанийг хөрөнгө оруулагчтай хамтран байгуулах, хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг батлах;

1.3. Тогтоолын 1.2-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан компани тус бүрт төслөө амжилттай хэрэгжүүлэхэд нь шаардагдах газар эзэмших эрх болон тус газар дээр тариалагдсан чацарганы моднууд, усалгааны зориулалттай газар доорх байгууламжийг шилжүүлэх;

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /Б.Бүрэн/-д даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтийн тухай тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тогтмол танилцуулж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 03-р сарын 26 өдөр

Дугаар 06

Хархорин сум

Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайланд тусгасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн гаргасан хувьцааны дүнтэй зөрүүг арилгах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 16 дугаар зүйлийн 16.2.2-ийг тус тус удирдлага болгон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн санхүүгийн тайлан тэнцлийн санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмч хэсэгт дүрмийн санг 836,220,266.63 төгрөг гэж тусгасан байгааг дараах байдлаар өөрчилсүгэй. Үүнд:

Дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгө: 53,951,500

Нэмж төлөгдсөн капитал: 782,268,766.63

Хоёр. Тогтоолын нэгд заасан өөрчлөлтийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал /Р.Саранцэцэг/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ